



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 1/158

Номгон

Г  
Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн  
100 хүүхдийн ортой дотуур байрны барилгын  
нэмэлт ажлын гэрээ байгуулах


Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а" дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 100 хүүхдийн ортой дотуур байрны барилгын ажлыг дуусгаж, барилгыг ашиглалтад оруулж, ашиглахтай холбогдуулан төсөвт тусгагдаагүй, зайлшгүй хийх шаардлагатай 33,198,713 төгрөгийн нэмэлт ажил дээр "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг үндэслэн гүйцэтгэгч компани болох "Жамъян пайтан" ХХК-тэй гэрээ байгуулсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т зөвшөөрсүгэй.

3. Нэмэлт ажлыг хурдан шуурхай зохион байгуулж, хийж гүйцэтгүүлэн хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Д.Алтангэрэл/-д даалгасугай.

4. Төсвийн тухай хуулийн 46.3.1 дэх заалтын дагуу нэмэлт ажлын төсвийг санхүүжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-т хариуцуулсугай.



Д.МӨНХСАЙХАН

601210061

D:\2021\Zakhiramj-2021 он\Zakhiramj-2021 он.docx